




МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ



**ШИВЭЭХҮРЭН-СЭХЭЭ, БИЧИГТ-ЗҮҮНХАТАВЧ, ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД
ХИЛИЙН БООМТЫН ТӨМӨР ЗАМ**

2023 ОН

ШИВЭЭХҮРЭН-СЭХЭЭ БООМТЫН ТӨМӨР ЗАМЫН ЭРХЗҮЙН ҮНДЭСЛЭЛ



2016

Шивээхүрэн-Сэхээ боомтын хил огтлолын цэг болон өндөржилтийг тогтоосон.

2018

Засгийн газрын 232 дугаар тогтоол:
“Нарийнсухайтын төмөр зам” ХХК-тай хамтарсан “Шивээхүрэн төмөр зам” ХХК-ийг байгуулах
Боомтын зориулалттай 13 км төмөр замын суурь бүтцийг барих.

2021

УИХ-ын “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоол:
Хилийн боомтуудыг төмөр замаар үе шаттайгаар бүрэн холбох

2022

Засгийн газрын 116 дугаар тогтоол:
Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх

2022

Засгийн газрын 446 дугаар тогтоол:
Шивээхүрэн-Сэхээ боомтын төмөр замын асуудлаар Хятадын талтай хэлэлцээ хийх.

ШИВЭЭХҮРЭН-СЭХЭЭ БООМТЫН ТӨМӨР ЗАМ



Шивээхүрэн боомт

Байршил: Өмнөговь аймгийн Гурвантэс сум, Өмнөговь аймгийн төвөөс 360 км, Улаанбаатар хотоос 1050 гаруй км алслагдсан.

Байгуулагдсан: 1993 он.

Боомтын хүчин чадал: Өдөрт зорчигч 800, тээврийн хэрэгсэл 600 нэвтрүүлэх боломжтой.

Сэхэ боомт

Байршил: ӨМӨЗО-ны Альша аймгийн Эзний хошуунд байрладаг. Жаичуан-Сэхэ төмөр зам, Линхэ-Сэхэ төмөр замуудаар болон авто замаар холбогддог.

Байгуулагдсан: 1992 он.

Боомтын хүчин чадал: Сэхэ боомтын авто замын нэвтрүүлэх эгнээ 8, төмөр замын ачиж буулгах 2 терминалтай.

Ачаа, тээврийн судалгаа

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт нүүрсний батлагдсан нөөц 6 тэрбум тонн, хэтийн нөөц 10 тэрбум тонн бөгөөд Нарийнсухайтын бүлэг ордын батлагдсан нөөц 1.6 тэрбум тн, хэтийн нөөц 3 тэрбум тн бөгөөд олборлолтыг жилд 24.5 сая хүргэх боломжтой.


Зорилго

Шивээхүрэн-Сэхээ хилийн боомтын төмөр замыг 2023 онд ашиглалтад оруулахаар төлөвлөж байгаа бөгөөд энэхүү төмөр замаар Нарийнсухайтын бүлэг ордоос авто замаар нүүрс тээвэрлэн Шивээхүрэн боомтод төмөр зам руу шилжүүлэн ачиж экспортод гаргах зорилтыг хэрэгжүүлнэ.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД



- ✓ Шивээхүрэн хилийн боомтын төмөр замын урьдчилсан Техник эдийн засгийн судалгааг боловсруулсан бөгөөд ТЭЗҮ-ийг “Монголын төмөр зам” ТӨХК боловсруулж, ЗТХЯ-ны ШУТЗ хурлаар батлуулсан.
- ✓ “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-ийн захиалгаар БНХАУ-ын “Төмөр замын зураг төслийн корпораци”-ийн /CRDC/ боловсруулж байгаа боомтын төмөр замын нарийвчилсан зураг төсөлд хяналт тавин ажиллаж байна.
- ✓ “Монголын төмөр зам” ТӨХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 23/04 тоот тогтоолыг үндэслэн “Монголын төмөр зам” ТӨХК – 51 хувь, “Нарийнсухайтын төмөр зам” ХХК – 49 хувийн оролцоотой “Шивээхүрэн төмөр зам” ХХК-г 2023 оны 03 сарын 01-ний өдөр байгуулсан.
- ✓ МУ-ын ЗГ-ын 05 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар Шивээхүрэн-Сэхээ боомтын хил дамнансан төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл болон барилгын ажлын зөвшөөрлийг олгосон.
- ✓ Монгол, Хятадын хилийн Шивээхүрэн-Сэхээ боомтын хил дамнансан төмөр замын бүтээн байгуулалтын талаар хятадын талтай хэлэлцээр хийж, талууд тохиролцсон.

ШИВЭЭХҮРЭН БООМТЫН ТӨМӨР ЗАМЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВЛӨЛТ




10 сая тонн

Өргөн цариг холбогдох



БИЧИГТ-ЗҮҮНХАТАВЧ БООМТЫН ТӨМӨР ЗАМЫН ЭРХЗҮЙН ҮНДЭСЛЭЛ



2016

Бичигт-Зүүнхатавч боомтын хил огтлолын цэг болон өндөржилтийг тогтоосон.

2021

УИХ-ын “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоол:
Хилийн боомтуудыг төмөр замаар үе шаттайгаар бүрэн холбох

2022

Засгийн газрын 116 дугаар тогтоол:
Хөөт-Чойбалсан, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх.



2022

Засгийн газрын 446 дугаар тогтоол:
Бичигт-Зүүнхатавч боомтын төмөр замын асуудлаар Хятадын талтай хэлэлцээ хийх

БИЧИГТ-ЗҮҮНХАТАВЧ ХИЛИЙН БООМТЫН ТӨМӨР ЗАМ

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД

- ✓ Бичигт боомтын төмөр замын ТЭЗҮ-ийг “Монголын төмөр зам” ТӨХК боловсруулж байгаа ба ажлын явц 40 хувийн гүйцэтгэлтэй байна.
- ✓ “МТЗ” ТӨХК “Ийст корридор рэйлрүүд” ХХК-тай Бичигт боомтын төмөр замын хээрийн судалгааны ажлыг хариуцан гүйцэтгэх тухай санамж бичгийг байгуулсан. Геологи, геодези, гидрогеологи, түгээмэл тархацтай ашигт малтмал, архелог, палеонтологи, БОННУ болон төслийн бэлтгэл ажилд шаардлагатай бусад ажлуудыг гүйцэтгэхээр санамж бичигт тусгасан.
- ✓ ЗТХЯ-ны ТНБД-ын баталсан “Бичигт-Зүүнхатавч боомтын хил дамнасан төмөр замын инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын даалгавар”-ыг “Ийст корридор рэйлрүүд” ХХК-д хүргүүлээд байна.



ГАСУУНСУХАЙТ ХИЛИЙН БООМТЫН ТӨМӨР ЗАМЫН ЭРХЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

2022

БНХАУ-ын ҮХШХ-ны ноот бичиг:

Гашуунсухайт-Ганцмод боомтын нарийн болон өргөн царигаар холбох, нүүрсний урт хугацааны цогц гэрээнд гарын үсэг зурах тухай

2022

Засгийн газрын хуралдааны тэмдэглэл:

Гашуунсухайт-Ганцмод боомтын төмөр замын бүтээн байгуулалт болон нүүрсний худалдааны Ерөнхий хэлэлцээрийг байгуулахыг “ЭТТ” ХК болон “ТТЗ” ХХК-д зөвшөөрсөн.

2022

Харилцан ойлголцлын санамж бичиг:

Монгол Улсын Сангийн Яам, ЗТХЯ болон БНХАУ-ын ҮХШХ-ны хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын холболтын тухай санамж бичигт гарын үсэг зурсан.

2022

Монгол Улс, БНХАУ хоорондын ерөнхий хэлэлцээр:


“Гашуунсухайт-Ганцмод боомтын төмөр зам болон нүүрс худалдах, худалдан авах ерөнхий хэлэлцээр”-т гарын үсэг зурсан.

2022

Засгийн газрын 435 дугаар тогтоол:

Бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тооцож, хэрхэн санхүүжүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг холбогдох засгийн газрын гишүүдэд даалгав.

ГАСУУНСУХАЙТ ХИЛИЙН БООМТЫН ТӨМӨР ЗАМ



	Өргөн цариг	Нарийн цариг
Гол замын урт /м/	8081	10888
Гүүрийн урт /м/	5441	4600
Өртөөний замын урт /м/		3300
Тахирын хамгийн бага радиус /м/	1200	1200
Хэвгий	6	11

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД

- ✓ Монгол, Хятадын хилийн “Гашуунсухайт-Ганцмод боомтыг холбох төмөр зам”-ын ТЭЗҮ, Иж бүрэн зураг төсөл боловсруулах ажлын гүйцэтгэгчийг ТБОНӨХБАҮХАТ Тухай хуулийн дагуу 2023.05.26-ны өдөр нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулан, Зөвлөх үйлчилгээний гэрээг “Төмөр замын зураг төслийн корпораци” /“China Railway Design Corporation”/ компанитай ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан.
- ✓ Боомтын бүтээн байгуулалтыг дэмжих талаар харилцан ойлголцлын “Санамж бичиг”-ийн хүрээнд талууд 2023.04.25-ны өдөр цахим уулзалтыг зохион байгуулан, уулзалтаар 2023 онд багтаан ТЭЗҮ, Иж бүрэн ажлын зураг төсөл боловсруулж, магадлуулах, мөн төслийн барилгын ажлыг 2024 оны 03-р сард эхлүүлэхээр хэлэлцэн, тохиролцсоны дагуу талууд бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.



МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

2023 ОН